

АЛС ДОРНОДЫН АСУУДЛААР БОЛСОН ГУРВАН ИХ ГҮРНИЙ КРЫМИЙН ХЭЛЭЛЦЭЭР, БНМАУ-ЫН СТАТУС-КВО

*Т.Төмөрхүлэг**

Дэлхийн хоёрдугаар дайны шувтаргаар буюу 1945 оны хоёрдугаар сард Крымд болсон гурван гүрний /ЗХУ, АНУ, Их Британи/ тэргүүн нарын бага хурлаар И.Сталин Японы эсрэг дайнд оролцох тэргүүн нөхцөл болгож БНМАУ-ын статус-квог АНУ, Англиар хүлээн зөвшөөрүүлснийг Монгол Улсын гадаад харилцааны түүхэнд онцгойлон авч үзэх учиртай нь гэвэл, чухам энэ үеэс тус улс олон улсын харилцаанд хөл тавих үүд хаалга нээгдэж эхлэсэн. Үүний оньсон түлхүүр нь Монгол Ард Улс юуны өмнө Гоминданы Хятадаар /БНХУ/ тусгаар тогтнох эрхээ хүлээн зөвшөөрүүлэхэд оршиж байв.

Сталины саналыг АНУ, Англи хүлээн авах болсон шалтгаан нь:

1. Герман бууж өгөн Европын дайн дууссаны дараа Японы эсрэг дайнд ЗХУ-ыг татан оролцуулахыг Рузвельт ихэд хичээж байв. Учир нь гэвэл АНУ дангаараа Японыг дарах юм гэхэд уг байлдаан сунжрах осолтой гэж үзсэн бөгөөд энэ нь АНУ-д хохиролтой хэмээн тооцоолж байв.

2. Гадаад Монгол 1911 оны эцсээс Манж гүрнээс салаад гуч гаруй жил өнгөрч Монголын тусгаар оршин тогтнох нь бодит зүйл болсон байв. Үүнд 1943 онд Каирт болсон гурван гүрний /АНУ, Англи, Хятад/ зөвлөгөөнд Гоминданы засгийн газарын төлөөлөгч Америкийн төлөөлөгчид хандан Монголыг Хятадын бүрэлдэхүүнд багтаахад Сталинд нөлөөлж өгөхийг хичээнгүйлэн хүсч байсан авч америкчууд, хятадуудын шаардлага бодит бус гэдгийг ухаалгаар ойлгож, түүндээ тулгуурлаж Крымийн бага хурлаар Монголын талаар гаргасан заалтыг Чан Кайшигийн засгийн газартай ярьж зөвшөөрүүлэхэд “холбогдох арга хэмжээ авах үүрэг”-ийг Сталины санал болгосноор Рузвельт ерөнхийлөгч хүлээн авсан гэж үзүүштэй.

Крымийн хэлэлцээрт Монголын талаар орсон заалт 1945 оны 6 дугаар сарын сүүлчээр эхлэсэн ЗХУ, Дундад Иргэн Улсын холбоотны гэрээ байгуулах хэлэлцээнд /Зөвлөлтийн талаас Сталин, Молотов, Хятадын талаас Засаг захиргааны Сун Зывень, Гадаад хэргийн Яамны сайд Ван Шице/ Зөвлөлтийн зүгээс БНМАУ-ын тусгаар тогтнолыг Гоминданы засгийн газраар хүлээн зөвшөөрүүлэх шаардлагын үндэс

*Т.Төмөрхүлэг - Онц бөгөөд бүрэн эрхт элчин, МУИС-ийн Түүх судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

болсон. /Уг хэлэлцээ 6 дугаар сарын 30-наас 7 дугаар сарын 12 хүртэл 6 удаа, 8 дугаар сарын 8-наас 14 хүртэл 4 удаа болсон/ Японтой дайн эхлэхээс өмнө Зөвлөлт-Хятадын холбоотны гэрээг байгуулахыг хятадууд их мэрийж байсан бөгөөд, нөгөөтэйгүүр ийм гэрээ байгуулах нь Хятадад иргэний дайныг эцэс болгон коммунистуудыг мохоон Чан Кайшигийн дэглэмийн байр суурийг бэхжүүлэхэд ашигтай гэж америкчууд үзэж байв. /ЗХУ тэр үед Хятадын коммунистуудыг биш Гоминданы намынхныг дэмжиж байсан/ Ийм ч учраас гол нь Монголын асуудлаас шалтгаалж урагшилж өгөхгүй байсан хэлэлцээг мухардалаас гаргахад, өөрөөр хэлбэл хятадуудыг уул асуудлаар буулт хийлгэхэд америкчуудын нөлөөлөл бас үүрэгтэй байсныг тэмдэглэх нь зүй. Хятадын төлөөлөгчдийн тэргүүн арга ядахдаа Москвад сууж байсан АНУ-ын элчин сайд Харриманаар уламжлуулан АНУ-ын Төрийн департаментаас АНУ Ялтын хэлэлцээрт гарын үсэг зурсан гүрний хувьд уг хэлэлцээрийн тухай /Гадаад Монголын тухай/ зөв тайлбар өгч Сталинтай цаашид хийх хэлэлцээнд үндэс болгохыг гуйсан ажээ. Гэвч Төрийн департамент хятадуудын тавьсан асуудлыг ДИУ, ЗХУ-ын хоорондын хэрэг тул Америкийн засгийн газарт хэлэх зүйл байхгүй гэсэн хариу өгсөн байдаг юм.

Хятадууд Крымын хэлэлцээрт Монголын талаар орсон заалтыг өөрийхөөрөө тайлбарлаж байв. Тухайлбал, эл хэлэлцээрт “Гадаад Монголын тухайн байдлыг хэвээр байлгана” гэснээс биш, “тусгаар тогтноулна” гээгүй гэх зэргээр маргалдаж байжээ. “Тухайн байдал” гэдэг нь Хятад-Зөвлөлтийн 1924 оны гэрээнд Гадаад Монголыг Хятадын салшгүй нэгэн хэсэг хэмээн заасныг хэлсэн байна гэж ойлгосон гэнцгээж байжээ. Иймээс ДИУ-ын төлөөлөгчид Монголын асуудлыг хэлэлцэхгүй гэж байсан. Сталин Гадаад Монголын тусгаар тогтнолыг хэлэлцэхгүй юм бол ЗХУ, ДИУ-ын найрамдал, холбоотны гэрээг хэлэлцэх шаардлагагүй гэж даралт шахалт үзүүлсэн. Сун Зывений хажуугаар Чан Кайшигийн хөвүүн Зян Зинго элгийнхээ заавраар Сталинтай биечлэн уулзаж “Японтой урт удаан хугацаанд байлдаж Манжуур, Тайванийг эгүүлж аваагүй цагт Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх нь Японы эсрэг дайныг утга учиргүй болгоно” гэх зэргээр тайлбарлаж байжээ. /Зян Зингогийн “Миний эцэг” гэсэн ном бий. Оросоор орчуулагдан гарсан/ Сталин үүнийг няцаахдаа, Зөвлөлт, Хятадын хэлэлцээр байгуулагдсанаар Японы эсрэг дайнд оролцох асуудлыг ойрын үед Потсдамын хэлэлцээгээр ярьж тогтох учиртай юм “ гээд “хэрэв уул хэлэлцээг таслах юм бол Хятадын тал бүхий л хариуцлагыг үүрч таарна шүү. Монголын тусгаар тогтнолыг зөвшөөрөхгүй юм бол

ЗХУ цэрэг гаргаж Японтой дайтаж чадахгүй, тэгэхээр Хятад улс Японд эзлэгдсэн хэвээр байх болно...” гэх зэргээр дарамт шахалт үзүүлсэн. Долдугаар сард Москвад Сталин Хятадын төлөөлөгчдөд ярихдаа “хэрэв ЗХУ Гадаад Монгол мэтийн жийрэг бүс газаргүй байх аваас Алс дорнодын нутаг дэвсгэрээ хамгаалж чадахгүй” гэсэн нь Монголын талаархи Зөвлөлтийн бодлогыг илэн далангүй хэлсэн хэрэг юм. Яг тэр үеэр буюу Хятадын төлөөлөгчдийг Москвад байх үеэр Чойбалсанг протоколын хувьд гадаад орны төрийн тэргүүний, хэмжээнд урьж айлчлуулсан нь мөн л хятадуудад шахалт үзүүлэх арга байжээ.

Долдугаар сарын 10-д Сун бээр Сталин, Молотов хоёрт Чан Кайшигийн явуулсан илгээлтийг гардуулжээ. Тэрхүү илгээлтэд Чан Кайши, Манжуур дахь ДИУ-ын эзэн эрхийг хүлээн зөвшөөрч, Порт-Артурыг хамтран ашиглах, Дайлянийг чөлөөт боомт болгохдоо Хятадын захиргаанд үлдээх, ДХТЗ-ыг хамтран ашиглах, ингэхдээ Хятадын мэдэлд байлгах, ЗХУ-ын зүгээс ХКН болон Шинжааны салан тусгаарлагчдыг дэмжиж туслахаа зогсоох аваас Ар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрч болох юм гэсэн санаагаар зөвлөлтийнхөнтэй ярилцахыг Сунд зааварласан тухайгаа мэдэгджээ. Хэлэлцээг урагшлуулахад Вашингтоны зүгээс, хятадуудад багагүй нөлөөлсөн бөгөөд Зөвлөлтийн талын байр суурь хөдлөхгүйг мэдмэгц Чан Кайши буулт хийж Гадаад Монголын статус-квог бүх ард түмний нь санал хураалт хүртэл буюу дайн дуусах үе хүртэл хэвээр үлдээхийг зөвшөөрч байгаагаа Сталин, Трумэн хоёрт 7 дугаар сарын 20-нд мэдэгдсэн. Ийнхүү Хятад Улс БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх асуудал шуударсан юм. Үнэндээ Хятад япончуудыг эх нутгаасаа хөөхөд холбоотон гүрнүүд, давын өмнө ЗХУ-ын цэргийн тусламжинд дулдуйдахаас өөр аргагүй нөхцөл байдалд эвтэйхэн сиймхий гарч хоёрдугаар дайны үр дагавар ч дам нөлөөлж тэр үеийн их гүрнүүдийн хүчний харьцааны онцлогоос Монголын тусгаар тогтнон орших эрхийг арга буюу хүлээн зөвшөөрөхөд хүрсэн юм.

1945 оны 8 дугаар сарын 14-нд ЗХУ, БНХУ-ын Гадаад хэргийн Яамны сайд нар Монголын тухай ноот бичиг солилцсон. Хятадын талын ноотонд “Японыг гарсаны дараа Гадаад Монголын ард түмэн тусгаар тогтнох хүсэл эрмэлзэлээ нотлох ахул Дундад Улсын засгийн газар Гадаад Монголын тусгаар тогтнолыг одоогийн хилээр нь хүлээн зөвшөөрөх болно” гэжээ. ЗХУ-ын Ардын комиссарын хариу ноотонд уг ноот бичгийг сэтгэл ханамжтай хүлээн авсанаа илэрхийлээд “Тус Зөвлөлт засгийн газар БНМАУ-ын төрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэж үзнэ” гэж дурдсан байгаа. /Монголд болсон бүх

нийтийн санал хураалт. 1946 оны эхээр БНМАУ, ДИУ хоёр дипломат харилцаа тогтоосон. Энэ бол Ар Монголын XX зууны Ар Монголын гадаад харилцааны түүхэнд гарсан томоохон үйл явдал мөн/

XX зууны Монголын дипломатын түүхийн нэгэн үе шатыг 1921-1945 оны багцаагаар авч үзэж болох бол энэ хугацаанд Гадаад Монгол тусгаар тогтносон улс байгаагүй, учир нь гэвэл ганц түшиж байсан ЗХУ нь хүртэл Хятадтай байгуулсан 1924 оны хэлэлцээрээр түүнийг Хятадын салшгүй хэсэг гээд хүлээн зөвшөөрчихсөн, Дундад Иргэн Улс Ар Монголыг 1945 онд л хүлээн зөвшөөрсөн гэж Рупен зэрэг Өрнөдийн түүхч бичсэн. Тэгвэл нэгэнт газар нутаг, хүн амтай, засаг төртэй улсыг гадаад гүрнүүд хүлээн зөвшөөрсөн зөвшөөрөөгүй, тусгаар улс гэж үздэг орчин үеийн олон улсын хууль цаазны баримтлал байдгийг Монголтой холбогдуулж энэ дашрамд дурдах нь зүйтэй.

Сталин Дундад Иргэн Улсаар БНМАУ-ын тусгаар тогтнолыг зөвшөөрүүлэхэд үлэмжхэн чармайлт гаргаснаар 1924 онд Хятадтай байгуулсан хэлэлцээртээ Монголын талаар тусгасан заалтыг арилгасан гэж үзэж болно.

1950 оны 2 дугаар сарын 14-нд ЗХУ, БНХАУ-ын Найрамдал, холбоо, харилцан туслах тухай Гэрээнд Москвад гарын үсэг зурахдаа, 1945 онд ЗХУ, Дундад Иргэн Улс хоёрын байгуулсан Гэрээ болон Хятадын Чаньчуны төмөр зам, Дайлянь, Порт Артурын талаарх хэлэлцээрийг хүчингүй болгохоо ноотоор харилцан зарлаад БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөх тухай мөн ноот солилцсон. Энэ бол “Зөвлөлтийн тал Гоминданы Хятадтай Монголын асуудлаар солилцсон ноотыг коммунист Хятадаар баталгаажуулж авсан хэрэг. Нэгэн үгээр хэлэхэд ЗХУ Гоминданы Хятадтай 1945 онд байгуулсан хэлэлцээрээс ганц хүчинтэй үлдсэн зүйл нь Монголын тухай асуудал юм.

ЗХУ, БНХАУ-ын 1950 оны Гэрээ 30 жилийн хугацаатай байгуулагдсан. 1980 онд Бээжингийн засгийн газар уг Гэрээг сунгахгүй гэдгээ мэдэгдсэн. Монголын тусгаар тогтнолын тухай хоёр этгээдийн солилцсон ноот бичиг уг Гэрээний бүрэлдэхүүн хэсэг мөн тул Гэрээнийхээ хамт хүчингүй болсныг Бээжинд 1993 онд хэвлэгдсэн “Ар Монголын тусгаар тогтнолын нууц үгсэл” номд дурдсан байна лээ. Гэхдээ үүнд эмзэглэх зүйлгүй. Учир нь гэвэл хөндлөнгийн хоёр этгээдийн тэрхүү хэлэлцээр хүчингүй болсноор БНХАУ Монголын тусгаар тогтнолыг баталгаажуулсан баримт бичиг үгүй болов гэж үзэх үндэсгүй. Энэ нь дараахь хоёр зүйлээр тайлбарлагдана. Үүнд, нэгд, аливаа орны бие дааж тусгаар тогтнон орших нь онолын хувьд хөндлөнгийн гүрнүүдийн

хэлцэл зөвшлийн хэрэг бус, энэ нь ялангуяа манай эрин үед тухайн ард түмний хүсэл эрмэлзэл, өөртөө итгэх чанар, амьдрах чадамж, засаг төрийнх нь ухаалаг бодлогоос ихээхэн шалтгаалах учиртай, хоёрт, хэрэв маргах асуудал гарах юм гэхэд БНМАУ, БНХАУ бие биеэ тусгаар улс хэмээн хүлээн зөвшөөрч дипломат харилцаа тогтоосон цаг хугацаа 1950 оны эхээр БНХАУ, ЗХУ хоёр Монголын тусгаар тогтнолын тухай ноот бичиг солилцсон өдрөөс хэдэн сарын өмнө болсон баримттай. Нөгөөтэйгүүр 1960 онд БНМАУ, БНХАУ-ын хооронд Найрамдал, хамтын ажиллагааны Хэлэлцээр, 1962 онд хилийн Гэрээнд тус тус гарын үсэг зурсан бөгөөд тус хоёр улс 1960 оны хэлэлцээрийг шинэчилж 1994 онд Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны Гэрээ байгуулсан, эл хэлэлцээрт хоёр этгээд бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг харилцан хүндэтгэн үзэх зүйл тусгаснаар БНХАУ, ЗХУ-ын Монголын талаархи 1950 оны ноот бичиг ач холбогдлоо нэгэнт алджээ гэж судлаачийн хувьд үзэж байна.

1945 онд Дундад Иргэн Улс буюу Гоминданы Хятадтай ЗХУ-ын байгуулсан Гэрээ, уг Гэрээний бүрэлдэхүүн хэсэг болох Монголын талаархи ноот бичиг, 1950 онд ЗХУ, БНХАУ-ын байгуулсан Хэлэлцээрийн дагалт Монголын талаар солилцсон ноот бичиг, 1949 оноос хойш БНХАУ-тай Монгол Улсын удаа дараа байгуулсан дээр нэр дурдсан Гэрээ бичгүүд нь цөм Алс дорнодын асуудлаар болсон гурван их гүрний Крымын хэлэлцээрт Монголын талаар тусгагдсан заалттай шижимийн холбоотой бөгөөд ийм ч учраас өнөөдөр бид түүнийг Монгол Улсын хувь заяанд нөлөө үзүүлсэн чухаг баримт бичиг гэж тооцох бүрэн үндэстэй юм.